



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар A/699

Мөрөн сум

Худалдан авах ажиллагааны газрын
орон тоо, бүтцийг өөрчлөн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар, Засгийн газрын 2023 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Зөвшөөрөл олгох тухай” 526 дугаар тогтоол, Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/374 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А-1/4038 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагааны газрын орон тоог нэгдүгээр, газрын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны “Худалдан авах ажиллагааны газар байгуулж, бүтэц, орон тоо батлах тухай” А/596 дугаар захирамжийн хоёр, гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

ПЛХАГВАЖАВ



d/zahiramj

6712011630

Аймгийн Засаг даргын 2023 оны
A/699-р захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ОРОН ТОО

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын орон тоо, бүтцийг дараах байдлаар батлав.

1. Газрын дарга-1
2. Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн-1
3. Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн-3
4. Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн-1
5. Хуулийн мэргэжилтэн-1
6. Нягтлан бодогч, архив бичиг хэргийн ажилтан-1
7. Хүний нөөц, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн-1
8. Нярав-жолооч-1

Аймгийн Засаг даргын 2023 оны 12-дугаар
А/69 Захирамжийн хоёрдугаар хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАГВАР



Газрын дарга

Ахлах мэргэжилтэн

Хүний нөөц, дотоод
хянгат, шалгалтын
мэргэжилтэн

Нягтлан бодогч, архив бичиг
хэргийн ажилтан

Худалдан авах
ажиллагаа
хариуцсан
мэргэжилтэн

Худалдан авах
ажиллагаа
хариуцсан
мэргэжилтэн

Хуулийн
мэргэжилтэн

Мэдээллийн
технологи
хариуцсан
мэргэжилтэн

Жолооч, нярав